ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2020/28/СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Дорнод аймаг

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: М.Ухаанбилэг

Утас: 70584207 Цахим хаяг: Ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

Агуулга

**Аудитын гэрчилгээ**....3
Аудитын тайлан ....5
2.1. Оршил....5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин....6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ....6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....8
2.12. Шилэн дансны мэдээлэл....8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ....8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....8
Менежментийн захидал ....10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ....12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ....123
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....134
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан....155
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....176
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....177

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.14 № 67

танай ____________ -ны № ____________ -т

БАЯН-УУЛ СУМЫН СУМ
ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Б.ДЭЛГЭРМАА ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519543

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус эмнэлгийн дарга Б.Дэлгэрмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 05–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баян-Уул сумын Сум дундын эмнэлэг нь “Эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэхэд оршино.” гэсэн үйл ажиллагааны эрхэм зорилготой ажиллаж байна.

Тайлант онд “Инээмсэглэл, эерэг хандлага” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Уул сумын Сум дундын эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoluos программ хангамж ашигладаг байна.

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 22 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 355,431.3 мянган төгрөгөөс тооцон 7,108.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,632.9 мянган төгрөг болсон нь санхүүжилт өмнө оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,804.4 мянган төгрөгөөр буюу 3,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 15,549.6 | 17,163.6 | 1,614.0 |
| Үндсэн хөрөнгө | 556,019.1 | 608,376.7 | 52,357.6 |
| Элэгдэл | -117,549.0 | -159,716.2 | -42,167.2 |
| **Нийт хөрөнгө** | 454,019.7 | 465,824.1 | 11,804.4 |
| Өр төлбөр | 0.0 | 239.9 | 239.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 454,019.7 | 465,584.2 | 11,564.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 454,019.7 | 465,824.1 | 11,804.4 |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд хэрэгжсэн төслийн хүрээнд ирүүлсэн материал, болон иргэдийн хандивын дүнгээр өмнөх оноос өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. Дээд шатны төсвийн захирагчаас 32,217.6 мянган төгрөг, ОНХС-аас 13,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, өөрийн хөрөнгөөр авсан 7,140.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан дүнгээр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд үйлдвэрчний эвлэл болон хүнс бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөгийн үлдэгдлийг тайлант тусгаагүй байсныг аудитын явцад залруулсантай холбоотой.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сум дундын эмнэлэг нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлаагүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 458,082.6 мянган төгрөгийг төсөв батлагдсан нь урсгал үйл ажиллагаанд 454,122.6 мянган төгрөгийг, хөтөлбөр төслийн арга хэмжээнд 3,960.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 433,604.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 24,478.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сан болон нийгмийн даатгалын сангийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 449,427.2 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас төслийн хүрээнд 22,629.4 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна. Энэ нь ЭМЯ-аас зохион байгуулсан эрт илрүүлгийн зардалд зарцуулагдсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 22 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 22 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 13,921.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 239,9 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,059.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,622.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 13,681.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5,059.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Баян-Уул сумын Сум дундын эмнээгийн УАЗ Пургон авто машины шатахуун зарцуулалтыг тооцон үзэхэд жишиг нормоос 919,3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Монгол Улсын дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-д нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Эрүүл мэндийн даатгалын сангаас ирүүлсэн төсвөөс 4,140.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1 дэх заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 8,622.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Баян-Уул сумын Сум дундын эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан доорх мэдээллүүдийг хугацаа хоцроон мэдүүлсэн байна.

1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /Тухай бүр/
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хам /Бүтэн жилээр, хагас жилээр, Улирал бүр, Сар бүр/
3. Байгууллагын батлагдсан төсөв /Бүтэн жилээр/

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8,600.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Орлогын данстай холбоотой асуудал*

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*
Иргэдээс хүлээн авсан 5,955.0 мянган төгрөгийн хандивын анхан шатны баримт байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1. дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтад нийцэхгүй байна.

*1.2. <u>Эрсдэл:</u>*
Ажил гүйлгээ данс бүртгэлд зөрүүтэй тусгагдах.

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>:*
НББ-ийн тухай хуулийн 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*
Иргэдээс өрөө тасалгааг тохижуулах хандив өгсөн болно. Анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллана.

*2. Зардлын дансны холбоотой асуудал*

*<u>2.1. Илрүүлэлт:</u>*
Тайлант хугацааны нийт худалдан авалтын 96.8 хувь татварын ебаримтад бүртгэгдсэн, QR бар кодтой баримтыг хавсаргасан байна. Худалдан авалтын нийт дүнгийн 3.2 хувь буюу 2,667.0 мянган төгрөгийн худалдан авалт бүртгэлгүй байна.
*<u>2.2. Эрсдэл</u>:*
Зориулалт бусаар зарцуулагдах
*<u>2.3. Өгсөн зөвлөмж:</u>*
Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан зааврын 6.5 дахь заалтыг мөрдөж ажиллах

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 15549570.00 | 17163638.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 0.00 |
| 33 | АВЛАГА | 0.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 15549570.00 | 17163638.00 |
| 351 | Түүхий эд материал | 0.00 | 57390.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 0.00 | 57390.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 525000.00 | 100000.00 |
| 354 | Хангамжийн материал | 15024570.00 | 17006248.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 29300.00 | 31450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12507090.00 | 15071890.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2319280.00 | 961400.00 |
| 35460 | Хүнсний материал | 168900.00 | 941508.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 438470171.86 | 448660561.49 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 438470171.86 | 448660561.49 |
| 392 | Биет хөрөнгө | 404470171.86 | 414660561.49 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 281346319.43 | 281346319.43 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -11818274.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31030600.00 | 31030600.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -14947266.61 | -19413933.25 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 89454101.00 | 122966701.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -47389217.32 | -59456402.02 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17205955.41 | 23050955.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16745604.47 | -17176308.10 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 102982207.00 | 115982207.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -38466922.58 | -51851303.94 |
| 393 | Биет бус хөрөнгө | 34000000.00 | 34000000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34000000.00 | 34000000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 454019741.86 | 465824199.49 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 239935.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 239935.00 |
| 413 | Өглөг | 0.00 | 239935.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 158735.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 81200.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 454019741.86 | 465584264.49 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 454019741.86 | 465584264.49 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 542615532.19 | 542615532.19 |
| 51101 | Өмч: - төрийн | 542615532.19 | 542615532.19 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -95029485.16 | -83464962.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -95029485.16 | -95029485.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 11564522.63 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6433694.83 | 6433694.83 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 454019741.86 | 465824199.49 |

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 366919980.00 | 543175484.01 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 0.00 | 0.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 40959000.00 | 67158741.01 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 40959000.00 | 21941141.01 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 40959000.00 | 21941141.01 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 40959000.00 | 21941141.01 |
| 121 | Хөрөнгийн орлого | 0.00 | 45217600.00 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 45217600.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 325960980.00 | 476016743.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 305000755.00 | 433604400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 305000755.00 | 433604400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1661900.00 | 9569500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1661900.00 | 9569500.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 19298325.00 | 32842843.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 120000.00 | 0.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 0.00 | 13060000.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 19178325.00 | 19782843.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 355431396.86 | 531610961.38 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 355431396.86 | 531610961.38 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 355431396.86 | 531597040.38 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 224577288.00 | 318859090.00 |
| 210101 | Үндсэн цалин | 155416987.00 | 205571535.00 |
| 210102 | Нэмэгдэл | 50359800.00 | 85639355.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 6006000.00 |
| 210104 | Урамшуулал | 18800501.00 | 21642200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26601300.00 | 40184382.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17967700.00 | 27487072.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1983300.00 | 3214502.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1773400.00 | 2571621.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 443400.00 | 628272.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4433500.00 | 6282915.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25365532.00 | 29013759.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3166332.00 | 3221459.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22199200.00 | 25684300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 108000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13113190.00 | 22992157.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 386050.00 | 2166370.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11091620.00 | 14323980.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.00 | 197000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1062060.00 | 1584370.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 573460.00 | 4720437.00 |
| 2105 | Нормативт зардал | 31803259.90 | 59352533.01 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19309809.90 | 45767061.01 |
| 210502 | Хоол, хүнс | 10863250.00 | 11130472.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1630200.00 | 2455000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1139000.00 | 6845280.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 896000.00 | 3983000.00 |
| 210604 | Урсгал засвар | 243000.00 | 2862280.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1022000.00 | 6200000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1022000.00 | 6200000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2180760.00 | 2451350.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500000.00 | 500000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54450.00 | 69300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68600.00 | 79200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16800.00 | 16800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1180100.00 | 1105600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 21600.00 | 21600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 61300.00 | 99000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 277910.00 | 559850.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29629066.96 | 45698489.37 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 979480.00 | 3531279.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28649586.96 | 42167210.37 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 13921.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 13921.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 13921.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 11488583.14 | 11564522.63 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.00 | 0.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 0.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 0.00 | 0.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 11488583.14 | 11564522.63 |
| | | | |
| | | | |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 325960980.00 | 476016743.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 0.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 325960980.00 | 476016743.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 305000755.00 | 433604400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 305000755.00 | 433604400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1661900.00 | 9569500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1661900.00 | 9569500.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 19298325.00 | 32842843.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 120000.00 | 0.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 0.00 | 13060000.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 19178325.00 | 19782843.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 325960980.00 | 476016743.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 325960980.00 | 476016743.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 325960980.00 | 476002822.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 224577288.00 | 318700355.00 |
| 210101 | Үндсэн цалин | 155416987.00 | 205412800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 50359800.00 | 85639355.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 6006000.00 |
| 210104 | Урамшуулал | 18800501.00 | 21642200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26601300.00 | 40184382.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17734200.00 | 27487072.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2216800.00 | 3214502.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1773400.00 | 2571621.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 443400.00 | 628272.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4433500.00 | 6282915.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25530932.00 | 27388859.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3031832.00 | 3221459.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22499100.00 | 24059400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 108000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13228520.00 | 20784500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 370200.00 | 2196500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11222800.00 | 14662700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.00 | 197000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1042000.00 | 1728300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 593520.00 | 2000000.00 |
| 2105 | Нормативт зардал | 30861050.00 | 37805000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18600000.00 | 24003120.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10281050.00 | 11821880.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1980000.00 | 1980000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 639000.00 | 18295797.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 396000.00 | 10719000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 3000000.00 |
| 210604 | Урсгал засвар | 243000.00 | 4576797.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 983700.00 | 6200000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 983700.00 | 6200000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2172050.00 | 2697850.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500000.00 | 500000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54450.00 | 69300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 68600.00 | 79200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16800.00 | 16800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1180100.00 | 1411950.00 |
| 210807 | Газрын төлбөр | 21600.00 | 21600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 61300.00 | 99000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 269200.00 | 500000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1367140.00 | 3946079.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1367140.00 | 3946079.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 13921.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 13921.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 13921.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 0.00 | 0.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 0.00 | 0.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 0.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 0.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 0.00 | 0.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 14 | Бусад эх үүсвэр | 0.00 | 0.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 0.00 | 0.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 0.00 | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **542,615,532.19** | **6,433,694.83** | **-95,029,485.16** | **454,019,741.86** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **542,615,532.19** | **6,433,694.83** | **-95,029,485.16** | **454,019,741.86** |
| **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **11,564,522.63** | **11,564,522.63** |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **542,615,532.19** | **6,433,694.83** | **-83,464,962.53** | **465,584,264.49** |

### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 458082600.00 | 453373322.00 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 458082600.00 | 453373322.00 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 458082600.00 | 453373322.00 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 323179600.00 | 318700355.00 |
| Үндсэн цалин | 206422200.00 | 205412800.00 |
| Нэмэгдэл | 89109200.00 | 85639355.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 6006000.00 | 6006000.00 |
| Урамшуулал | 21642200.00 | 21642200.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40397500.00 | 40184382.00 |
| Тэтгэврийн даатгал | 27470300.00 | 27487072.00 |
| Тэтгэмжийн даатгал | 3231800.00 | 3214502.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2585400.00 | 2571621.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 646400.00 | 628272.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 6463600.00 | 6282915.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27389400.00 | 27388859.00 |
| Гэрэл, цахилгаан | 3200000.00 | 3221459.00 |
| Түлш, халаалт | 24000000.00 | 24059400.00 |
| Цэвэр, бохир ус | 189400.00 | 108000.00 |
| Байрны түрээс | | |
| **Хангамж, бараа материалын зардал** | 17348800.00 | 17348800.00 |
| Бичиг хэрэг | 466800.00 | 466800.00 |
| Тээвэр, шатахуун | 13010000.00 | 13081700.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 72000.00 | 72000.00 |
| Ном, хэвлэл | | |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1800000.00 | 1728300.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2000000.00 | 2000000.00 |
| Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **Нормативт зардал** | 35855000.00 | 35855000.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 23000000.00 | 23000000.00 |
| Хоол, хүнс | 10875000.00 | 10875000.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1980000.00 | 1980000.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5252000.00 | 5251997.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 396000.00 | 396000.00 |
| Тавилга | 3000000.00 | 3000000.00 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| Урсгал засвар | 1856000.00 | 1855997.00 |
| **Томилолт, зочны зардал** | 2000000.00 | 2000000.00 |
| Гадаад албан томилолт | | |
| Дотоод албан томилолт | 2000000.00 | 2000000.00 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2700300.00 | 2697850.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500000.00 | 500000.00 |
| Даатгалын үйлчилгээ | 69300.00 | 69300.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 79200.00 | 79200.00 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16800.00 | 16800.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1414000.00 | 1411950.00 |
| Газрын төлбөр | 22000.00 | 21600.00 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99000.00 | 99000.00 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 500000.00 | 500000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3960000.00 | 3946079.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3960000.00 | 3946079.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 453689600.00 | 449427243.00 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 429211400.00 | 429644400.00 |
| Улсын төсвөөс санхүүжих | 429211400.00 | 429644400.00 |
| **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 24478200.00 | 19782843.00 |
| Хандив тусламж /дотоод/ | 24478200.00 | 19782843.00 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |